

Цахилгаан эрчим хүчний хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдлын талаар хэрэглэгчдэд зориулсан зөвлөмж

1. Цахилгааны тоолуурын ажиллагаанд хяналт тавих талаар:



- Цахилгааны тоолуур нь баталсан загвар, улсын стандарт, техникийн болон ашиглалтын шаардлагыг хангасан байна.
- Цахилгааны тоолуурын баталгаажуулалтыг хэмжил зүйн байгууллагаас улсын шалгагчийн эрх олгосон ажилтан гүйцэтгэнэ.
- Баталгаажуулалтад тэнцсэн тоолуурт хэмжил зүйн төв байгууллагаас баталсан тэмдэг дарах ба лацдаж гэрчилгээ олгоно.
- Хэмжил зүйн байгууллагаас тоолуур суурилуулах, засвар тохируулга хийх, худалдах тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага тоолуур суурилуулна, засвар тохируулга хийнэ, худалдана.
- Тоолуурт баталгаажуулалт, засвар, шалгалт тохируулгыг хийхдээ баталгаатай эталоныг ашиглана.
- Шалгалт тохируулга хийсэн хэмжих хэрэгсэлд шалгасан тэмдэг дарах буюу шалгалт тохируулгын гэрчилгээ олгож, ашиглалтын баримт бичиг тэмдэглэнэ.
- Тоолуурын хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдалд Мэргэжлийн хяналтын төв, орон нутгийн хэмжил зүйн байцаагчид болон “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хуулиар эрх олгогдсон улсын байцаагчид төрийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллана.
- Аж ахуйн нэгж байгууллага эрхэлсэн ажил үйлчилгээнийхээ хүрээнд хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хариуцах бөгөөд баталгаажуулалт, засвар, шалгалт тохируулга гүйцэтгэсэн үйлчилгээний зардлыг хариуцах, хэмжих хэрэгсэлийг тогтоосон хугацаанд нь баталгаажуулалтад хамруулах үүрэгтэй.
- Хэрэглэгчээс хүсэлт тавьсан тохиолдолд хангагч тоолуурыг үнэ төлбөргүй шалгаж өгнө.
- Шалгалтын үр дүнд тоолуур нь холбогдох стандартын шаардлага хангаж байвал хэрэглэгч батлагдсан тарифын дагуу шалгалт хийсэн үйлчилгээний хөлсийг төлнө.
- Шалгалт хийсэн дүн, тоолуур сольсон тухай хангагч байгууллага хэрэглэгчид мэдээлэл өгч, танилцуулна.
- Тоолуурын битүүмжлэлийг алдагдуулсан, тоолуурыг тойруулан залгаснаас бусад тохиолдолд хэрэглэгчийн тоолуурын заалт ажиллахгүй болсон бол хангагч байгууллага өмнөх жилийн мөн үеийн эсвэл өмнөх гурван сарын хэрэглээний дундажийг үндэслэл болгон төлбөр тооцоо хийнэ.
- Аж ахуйн нэгж, иргэн тоолуурыг оролдох, тойруулж холболт хийх, буцааж эргүүлэх, зэргээр битүүмжлэлийг алдагдуулах нь хууль бус үйлдэл болно.



- Тоолуурын заалт авалт, төлбөр тооцоо, үнэ тарифтай холбоотой хангагч, хэрэглэгчдийн хооронд гарсан маргааныг Эрчим хүчний Зохицуулах хороо, аймаг, нийслэлийн эрчим хүчний Зохицуулах Зөвлөл шийдвэрлэнэ.

2. Трансформаторын хоосон явалтын талаар:



- Трансформатор гэдэг нь хэрэгцээт хүчдэлийн өндөр нам байх шаардлагаас хамаарч хүчдэлийг өсгөх, бууруулах зориулалт бүхий төхөөрөмж бөгөөд хэрэглэгчдийн хувьд голдуу бууруулах трансформаторууд тавигдсан байдаг.
- Трансформатор бүрт түүний чадал, нэг, хоёрдугаар ороомгийн гүйдэл, хоосон явалтын алдагдал, хоосон явалтын гүйдэл зэрэг хэвийн ажиллагааны үеийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон байдаг.
- Ачаалалгүй трансформаторын хоосон явалтын алдагдал нь хоосон явалтын гүйдлээр тодорхойлогдоно. Энэ нь трансформаторын чадал, нэгдүгээр ороомгийн гүйдэл хичнээн их байна төдий хэмжээгээр алдагдал их байх ойлголт юм. Иймд хэрэглэгч та өөрийн хэрэглээнд тохирсон чадал бүхий трансформаторыг сонгох нь хоосон явалтын алдагдлыг бага байлгах сонгодог арга болно.
- Трансформатораас ямар нэг цахилгааны хэрэглээ аваагүй байхад уг трансформатор цахилгаан шугамд холбоотой л бол хоосон явалтын алдагдал хэмээх хэрэглээтэй байх бөгөөд энэ нь таны тоолуураар байнга тоологдох болно.
- Хэрэглэгч таны цахилгааны хэрэглээний чадлаас хамаарч хоосон явалтын коэффициентийг тодохойлдог. Таны сонгож тавьсан трансформаторын чадал хэрэглээний чадлаас их байх тутам хоосон явалтын коэффициент өндөр тодорхойлогдох бөгөөд энэ хэмжээгээр танд ашиггүй байхыг анхаарах. Иймд хэрэглээний чадалдаа тохирсон трансформатор тавихыг танд зөвлөж байна.

3. Цахилгаан хэрэгсэл шатсан тухай гомдол, хүсэлтийг шийдвэрлэх талаар:

Хэрэглэгч нь цахилгаан хэрэгсэл шатсан тухай өргөдлөө Хэрэглэгчдэд үйлчлэх төвд өгнө. Хэрэглэгчдэд үйлчлэх төвөөр дамжин ирсэн өргөдлийн дагуу тухайн түгээх төвийн ашиглалтын

инженерээр ахлуулсан комисс цахилгаан хэрэгсэл шатсан шалтгааныг судалж, хэрэглэгчдэд учирсан хохирлыг газар дээр нь үзэж хэрэглэгчтэй хамтран акт тогтооно.

Хэрэглэгчийн өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, хэрэглэгчийн хохирлыг барагдуулна. Дараах тохиолдлуудад хохирлыг түгээх төв хариуцахгүй болно. Үүнд:

- Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулаагүй;
- “УБЦТС” ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй шугам сүлжээнд холбогдоогүй;
- Цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурваст байршсан;
- Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 10-р зүйлийн 50-р заалтууд болох байгалийн гэнэтийн аюул (аянга, салхи, шуурга, мөстлөг, үер, гал түймэр) тохиолдсон, хангагчтай тохиролцсон горимыг хэрэглэгч мөрдөөгүйгээс хэрэглэгчийн цахилгаан хангамж тасарсан, Эрчим хүчний тухай хуулийн 29.1.2, 32.2-т заасны дагуу хэрэглэгчийн цахилгаан хангамжийг тасалсан, түдгэлзүүлсэн, хэрэглэгчийн цахилгаан дамжуулах шугамыг гуравдагч этгээд гэмтээж эрчим хүчээр тасалдуулсан;

4. Гэрлийн хүч муу, хүчдэлийн уналттай холбоотой гомдол, хүсэлтийг шийдвэрлэх талаар:

Өргөдөл гаргаж тухайн Түгээх төвийн хариуцсан мэргэжилтэнд хандана. Өргөдөл хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногт гэрлийн хүч сайжруулах боломжтой, эсэх талаар хариуг өгнө. Хүчдэл сайжруулах боломжтой тохиолдолд ажлын 7 хоногт шийдвэрлэнэ.

5. Таслалт хязгаарлалтын талаар

- Зайлшгүй таслалт: Тоног төхөөрөмжийн гэмтэл, саатал зэргээс шалтгаалж автоматаар эсвэл гараар таслахыг;
- Төлөвлөгөөт таслалт: барилга байгууламж барих, урьдчилсан засвар хийх зорилгоор хэрэглэгчдийн хүлээн зөвшөөрсөн таслалтыг;
- Гэнэтийн таслалт: үйлдвэрлэлт, дамжуулалтын дэд станцын таслалтаас шалтгаалж;
- Гэнэтийн үйл явдлын үеийн : Газар хөдлөлт, хүчтэй салхи шуурга, зэрэг байгалын гамшгаас хамаарч;
- Түр хугацааны таслалт: хүчдэлийн түшин О хүртэл багасч дахин хэвийн болох үеийн;
- Үргэлжилсэн хугацааны таслалт: Түр хугацаанаас бусад таслалтыг;

Таслалтын тухай тэмдэглэлийг түгээгч, хангагч байгууллагууд хөтлөнө. Тэмдэглэл бүртгэлд таслалтын төрөл, шалтгаан, таслалтад хамрагдсан хэрэглэгчдийн тоо, дахин давтагдахыг зогсоох зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэргийг тэмдэглэнэ. 24 цагаас дээш хугацаагаар үргэлжилсэн томоохон таслалт болсноос хойш ажлын 5 хоногт багтаан тайлангаа ЭХЗГ-т ирүүлнэ. Тайланд таслалт болсон цаг хугацаа, таслалтын шалтгаан, байршил, таслалтад хамрагдсан хэрэглэгчдийн тоо, хэсэгчилсэн буюу үе шаттайгаар хэвийн горимд оруулсан цаг хугацаа, хэрэглэгчдийн тоо, минутын хэмжээ, хамрагдсан хэрэглэгчдийн тоог үргэлжилсэн хугацаагаар үржүүлсэн үзүүлэлт зэрэг орно.